

ДУНДГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН 2015 ОНЫЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2015 оны 12 р сарын 30 ныөдөр

Мандалговь

Тус статистикийн хэлтэс нь МУ-ын Статистикийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг удирдлага болгон, ҮСХ-ны дарга, аймгийн статистикийн хэлтсийн дарга нарын хооронд байгуулсан үр дүнгийн гэрээ, удирдлагуудаас өгсөн ажлын чиглэл, тогтоол шийдвэрүүдийг үндэслэн албан ёсны статистикийн мэдээллийн хамрах хүрээг нэмэгдүүлэх, үнэн зөв, шуурхай бодит байдлыг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглалтыг сайжруулах, судалгааны чанарыг дээшлүүлэх, мэргэжилтнүүдийн ажлын хариуцлагыг дээшлүүлэн идэвхи санаачлага, бүтээлч ажиллагааг эрчимжүүлэх, аймгийн хөдөө аж ахуйн байдал, хүн амын чиглэлээр танилцуулга бэлдэх, хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллийн сангийн хөтлөлтийн сайжруулах, мэдээллийн цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх, мэдээллийн технологи портал вэб сайтын баяжилтыг хангах, хэрэглэгчдэд үйлчлэх зорилтуудыг өмнөө тавьж амжилттай хэрэгжүүлэн ажиллаа.

I БҮЛЭГ: АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ХАМРАЛТ, ДАМЖУУЛАЛТ

1.МЭДЭЭНИЙ ХАМРАЛТ (Ш1)

Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны 1 сарын 16-ний А/06 тоот тушаалаар батлагдсан нийслэл, аймгийн статистикийн газар хэлтсээс ҮСХ-д 2015 онд ирүүлэх албан ёсны статистикийн мэдээ, тайлангийн нэгдсэн графикийг мөрдөж, оны эхэнд ирсэн хүрээгээр аж ахуйн нэгжүүдийг бүрэн хамруулж, давхардсан тоогоор 80 гаруй мэдээ тайлан, судалгааг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан.

2015 онд ирүүлэх албан ёсны статистикийн мэдээ, тайлангийн нэгдсэн графикийг Аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга нартай байгуулсан ажил дүгнэх үзүүлэлтэнд оруулж биелэлтийг аймгийн Засаг дарга хагас, бүтэн жилээр тооцон ажиллаж байна.

Хүснэгтэн мэдээлэл

Мэдээний хүрээнд зайлшгүй өөрчлөлт орох тохиолдолд холбогдох газар, хэлтсийн мэргэжилтэнтэй тохирч байгаа учир мэдээний хамралт 100 хувьтай байгаа юм.Тайлан жилд мэдээний тасалдал, хожимдол гаргаагүй, мэдээний графикт өдрийн 17 цагт багтаан мэдээг хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн өөрийн биеэр нэг бүрчлэн шалгаж, мэдээ мэдээллийн чанарын асуудалд анхаарлаа хандуулан, хамралт бүрэн байгаа эсэхийг үзэж, холболтыг хийж дамжуулдаг.

2. МЭДЭЭНИЙ ДАМЖУУЛАЛТ (Ш2)

2015 оны жилийн эцсийн байдлаар ҮСХ-д гаргаж өгвөл зохих мэдээг 100 хувь хугацаанд нь гаргаж, дамжуулбал зохих графикт өдөр нь бүрэн дамжуулсан. Энэ онд

мэдээ дамжуулах, холболт хийхэд ямар нэг саатал гараагүй үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.Сар бүрийн 4, 5, 21, 28-нд нийт сард 4 удаа мэдээ дамжуулж байна.Мөн 7 хоног бүрийн 3 дахь өдөр үнийн мэдээг тогтмол дамжуулж хэвшсэн.

Мэдээнүүдийг програмын дагуу шивж, алдааг бүрэн засварлан үр дүнгийн хүснэгтийг үүсгэн өнгөрсөн мөн үе болон өмнөх сарын мэдээтэй уялдуулан шалгаж, тодруулах шаардлагатай мэдээг ААНэгжүүдээсээ тодруулан шалгадаг.

Цахим холболтоор дамжуулсан мэдээний бүртгэлийг мэргэжилтнүүд өөрсдөө тогтмол хөтлөхийн зэрэгцээ үндсэн бүртгэлийг ахлах мэргэжилтэн нэгтгэн хөтөлж заншсан.

Нийт 62 нэрийн давхардсан тоогоор 1731 мэдээг 100 хувь хугацаанд нь бүрэн интернетээр дамжуулсан. Үүнд хөдөө аж ахуйн 390, аж үйлдвэрийн 117, тээврийн 9, зочид буудал, зоогийн газрын 87, худалдааны 344, үсчин гоо сайхны 4, төрийн бус байгууллагын 68, мал эмнэлгийн 84, сүм хийдийн 31, барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний 59, мэргэжлийн түр сургалтын 12, холбооны 12, орон сууц нийтийн аж ахуйн 1, бизнес регистрийн 108 аж ахуйн нэгжийн мэдээллийг тус тус тогтоосон хугацаанд нь бүрэн мэдээллээ. Харин сонгогдсон аж ахуйн нэгж тухайн сард үйлдвэрлэл явуулаагүй тохиолдолд мэдээ бүрийн тайлбарыг хамт явуулж байлаа.

3. МЭДЭЭНИЙ БОДИТ БАЙДАЛ, ЧАНАР (ШЗ)

Үндэсний Статистикийн Хороонд дамжуулах мэдээ тайланг салбар хариуцсан мэргэжилтнүүд сумд болон мэдээлэгчдээс шалган авч програмд боловсруулсны дараа хэлтсийн ахлах мэргэжилтэн хүлээн авч логик шалгалтуудыг хийж өнгөрсөн оны болон өмнөх сарын гүйцэтгэлүүдтэй зэрэгцүүлэн үзэж баталгаажуулан төвд мэдээлж байснаар мэдээ тайлангийн алдаагүй ажиллаж байна.

Хэлтсийн дарга, мэргэжилтнүүд мэдээний үнэн зөв байдалд байнгын хяналт хийж 15 сумын аж ахуйн нэгж, төрийн сан, багийн засаг дарга, нарт анхан шатны мэдээний бүртгэлийг сайжруулах талаар зөвлөмж өгч ажилласан.

Шинээр орсон мэргэжилтнийг чадваржуулах зорилгоор, мэргэжилтнүүд мэдээг нь хамтран шивж, зааж сургах, алдааг шалгах талаар заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.

Албан ёсны статистик мэдээ, мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавих зорилгоор хэлтсийн дарга болон мэргэжилтнүүд жилийн эцсийн байдлаар Луус, Хулд, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Гурвансайхан, Баянжаргалан, Адаацаг, Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Дэрэн зэрэг 15 суманд 2 удаа ажиллаж багийн засаг дарга нарын сарын мэдээний анхан шатны хөтөлгөө болон түүний үнэн бодит байдал, хагас жилийн малын түүвэр судалгааны явц, зохион байгуулалтанд хяналт хийхийн

зэрэгцээ бусад багийн дарга нарын туршлагыг хуваалцан зөвлөгөө өглөө.



Мөн томилолтын хугацаанд сумдын төрийн сангийн мэргэжилтэн болон багийн засаг дарга нарт ХАӨМС-ийн одоогийн байдал цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, ХАОС-ны завсрын тооллогын захирамж гарсан эсэх, тооллогоор хэрхэн ажиллах зэрэг цаг үеийн асуудлаар хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу ажиллаа.

4. ХҮН АМ, ӨРХИЙН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САН (Ш4)

2015 оны Хүн ам орон сууцны завсрын тооллого нь хүн ам өрхийн мэдээллийн сан дахь бүртгэлд суурилан явагдаж байгаатай холбоотойгоор мэдээллийн санг шинэчлэх ажил аймгийн хэмжээнд хийгдэж байна. Багийн засаг дарга, төрийн сангийн төлөөлөгчдөд мэдээллийн сангийн талаар өрхийн бүртгэлийн дэвтрийг хөтлөх талаар 2 удаагийн сургалтыг амжилтай зохион байгууллаа

Хүн ам, орон сууцны завсрын тооллогын ажлын хүрээнд хэлтсийн даргын 2015 оны 4 сарын 23 ны өдрийн 20 тоот албан бичиг, 2015 оны 5 сарын 15 ны өдрийн 26 тоот албан бичгийг тус тус сумдад хүргүүлж хүн амын мэдээллийн сангийн мэдээллийг засварлах шалгах ажлыг идэвхжүүлж ажилласан. ҮСХ-ноос 14 хоног тутам уншуулан ирүүлж байгаа алдааг сум тус бүрээр ялган сумдад хүргүүлэн засварлах, алдаа ихтэй сумдад хэлтсийн мэргэжилтнүүд гэрээт ажилтад хамтран алдааг засварлалаа. Аймгийн хэмжээнд хамгийн их алдаатай Сайнцагаан, Гурвансайхан суманд албан бичиг хүргүүлэн ажиллаж байна.



Хүн ам өрхийн мэдээллийн санд байхгүй боловч УБЕГазрын мэдээллийн санд байгаа 2052 хүний нэр ирсэнийг тодруулан 12 сарын 1-н байдлаар 2018 хүний мэдээллийг өрхөд нь бүрэн орууллаа. Үлдсэн 34 хүн нь өөр регистрийн дугаараар ХАОМС-д орсон, манай аймагт байхгүй олон жилийн өмнө шилжсэн, зарим нь нас барсан хүн байна. Эдгээр хүмүүсийн тайлбарыг хүргүүллээ. Мөн нас барсан хүний мэдээлээ мэдээллийн санд тэмдэглээгүй хүмүүсийн жагсаалтыг сум багт нь хэлж тэмдэглүүллээ. 2015 онд шинээр төрсөн хүүхдүүдийг ҮСХ-ноос 11 сарын 19 нд ирсэн





файлын дагуу мэдээллийн санд оруулах ажил хийгдэж байна. Асран хамгаалагч

буюу аав нь тухайн аймаг сумын иргэн биш 35 хүүхдийн мэдээлэл оруулаагүй хүлээгдэж байгааг Улсын бүртгэлийн хэлтсээс тодруулахаар ажиллаж байна. 2015 оны 10 11 12 сард шинээр төрсөн хүүхдийн мэдээлэл мэдээллийн санд орохгүй байж байгаад 12 сарын 29 нөөс хойш оруулж байна. Аймгийн хэмжээнд шилжилт батлахаар хүлээгдэж буй 800 гаруй хүнийг сумдаас нь тодруулахад иргэний бүртгэлээс албан ёсоор шилжээгүй , 183 хоногоос доош хугацаагаар өөр аймаг нийслэлд байгаа, эмчилгээнд түр явсан хүмүүс, эцэг эх, гэр бүлийнхэн нь өрхөөсөө хасуулахгүй , түр эзгүйгээр бүртгүүлэхгүй байгаа гэх мэт тайлбарыг програмын тэмдэглэл хэсэгт тэмдэглэсэн. Мөн хаягийн мэдээлэл байхгүй НДЕГ-ийн мэдээллийн сантай тулган ирсэн хүмүүсийн мэдээллийг Улсын бүртгэлийн хэлтэс, сумдын БЗД нартай хамтран тодрууллаа. Тэдгээр хүмүүсийн дотор олон жилийн өмнө нас барсан, шилжин явсан, регистрийн дугаар давхардсан хүмүүс ихэнх нь байсан бөгөөд програмд оруулаагүй орхигдсон хүмүүсийг оруулж тухайн файлыг тайлбарын хамт хүргүүллээ.

ХҮН АМ ОРОН СУУЦНЫ ЗАВСРЫН ТООЛЛОГО

Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогын хүрээнд тооллогын комиссыг Аймгийн Засаг даргын 2015 оны 04 сарын 23 ны өдрийн А/152 тоот захирамжаар томиллоо. Тооллогын комиссын даргаар аймгийн Засаг дарга С.Од-эрдэнэ, Тооллогын комиссын орлогч даргаар Хэлтсийн дарга Н.Түвшинжаргал, нарийн бичгийн даргаар хэлтсийн Ахлах мэргэжилтэн Ж.Уянга нарыг, тооллогын комиссыг 12 гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгууллаа.



Мөн тооллогын комиссын хурлыг зохион байгуулж энэ удаагийн тооллогын онцлого зохион байгуулалтын талаар танилцуулж цаашид комиссын гишүүд яаж хамтарч ажиллах талаар ярилцлаа.



Сумдадаа комисс байгуулан ажиллах талаар албан бичгийг 2015 оны 4 дүрээр сарын 23 ны өдөр бүх сумдадаа хүргүүлэн, сумдад сумын Засаг даргаар ахлуулсан тооллогын комисс байгуулагдан төлөвлөгөө гарган ажиллаж байна. Аймгийн тооллогын комисс 5-р сард хуралдан тооллогын ажлын төлөвлөгөөг хэлэлцэж 2015 оны 6-р сарын 10 ны өдөр Аймгийн Засаг даргаар батлууллаа. Энэ хугацаанд тооллогын комисс 2 удаа хуралдан цаг үеийн шаарлагатай ажлын талаар хэлэлцлээ.

БАТЛАВ
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА *[Signature]* С.ОД-ЭРДЭНЭ

ДУНГОВЬ АЙМГИЙН ХҮН АМ ОРОН СУУЦНЫ ЗАВСРЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ


2015.06.10

№	Хийгдэх үйл ажиллагаа	Хариуцах эзэн	Хугацаа
1	Хүн ам, орон сууцны завсрын тооллогын комисс байгуулах	Хэлтсийн дарга	4 сард
2	Хүн ам, орон сууцны завсрын тооллогын төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	Хэлтсийн дарга, комиссын гишүүд	5 сард
3	Сумын статистик мэдээ хариуцсан мэргэжилтэн болон багийн засаг дарга нарын сургалт хийх	Хэлтсийн дарга, мэргэжилтнүүд	9 сард
4	Аймаг, нийслэлийн статистикийн хэлтсээс ХАӨМС-ийн өрхийн дугаар, регистрийн дугаарын давхардал, алдааг арилгаж, тодруулга хийсэн мэдээллийг авч, нягтлах, нэгтгэх, дахин тодруулга хийх	Ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүд	4-9 сард
5	ХАӨМС-ийн шивэлтийн алдаа, үнүүлэлтийн бүрэлдт, хамралтыг сайжруулах ажилд дэмжлэг үзүүлж ажиллах гэрээт ажилтныг сонгон шалгаруулж, томилох	Хэлтсийн дарга	5 сард
6	ХАӨМС-ийн шивэлтийн алдаа, үнүүлэлтийн бүрэлдт, хамралтыг сайжруулах ажилд дэмжлэг үзүүлж ажиллах гэрээт ажилтны сургалтыг зохион байгуулах, ажиллуулах	Хэлтсийн дарга, мэргэжилтнүүд	6-12 сард
7	ХАӨС-ны завсрын тооллогын ажилд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Хэлтсийн дарга, нягтлан бодогч	6 сард
8	Аймаг, сум, багийн ХАӨМС-д хяналт, үнэлгээ хийх	Хэлтсийн дарга, мэргэжилтнүүд	9-12 сард
9	Аймаг, сум, багийн ХАӨМС-д хяналт, үнэлгээ хийсэн талаарх танилцуулга бичиж тооллогын хороонд танилцуулах	Хэлтсийн дарга, мэргэжилтнүүд	11-12 сард
10	ХАӨМС-ийн мэдээллийг баяжуулах, бүртгэлийн ач холбогдолыг таниулах "Нээлттэй хаалтаны өдөрлөг"-ийг баг, хороонд нэгдсэн журмаар зохион байгуулах	Хэлтсийн дарга, мэргэжилтнүүд	8-12 сард

11	Цаг үеийн шаардлагаар зарим сумдад хэлтсээс очиж ажиллах	Хэлтсийн дарга, мэргэжилтнүүд	8-10 сард
12	Багийн засаг дарга нарт анхан шатны хөтөлгөөний дэвтэр хэвлүүлэх	Хэлтсийн дарга, мэргэжилтнүүд	8-9 сард
13	Завсрын тооллогын үр дүнг ХАӨМС-аас уншуулахад бэлтгэх	Хэлтсийн дарга, мэргэжилтнүүд	11-12 сард
14	Завсрын тооллогын хүн амын нэгтгэлийг гаргах, тайлагнах	Хэлтсийн дарга, мэргэжилтнүүд	2016 оны 2 сард
15	Завсрын тооллогын үндсэн үр дүнг танилцуулах	Хэлтсийн дарга, мэргэжилтнүүд	2016 оны 4 сард

Төлөвлөгөө боловсруулсан:
Статистикийн хэлтсийн дарга *[Signature]* Н.Түвшинкаргал

ХАОСТ-ын төсвийн задаргааг хэлэлцэн Аймгийн Засаг даргын 2015 оны 6 дугаар сарын 8 ны өдрийн а/216 тоот захирамжаар батлуулсан. Тооллогын төсвийг зориулалтын дагуу зарцуулан Аймгийн нийт өрхийн тоогоор өрхийн бүртгэлтийн дэвтэр хэвлүүлэн сумдад тараан бүх сумдад холбоо, зар сурталчилгаа, шатахууны зардал тусган төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.



БАТЛАВ
ЗАСАГ ДАРГА С.ОД-ЭРДЭНЭ

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2015 ОНЫ ЗАВРСЫН ТООЛЛОГЫН ЗАРЛАГ

2015.05.27

Үндсэн мэдээлэл	Гэрээт ажилтны шалт, нөхцөл		Бүртгэл нийт зардал		Сургалтын зардал		Сурталчилганы зардал		Төсө / төлөвлөгөө		Хяналт, нэмэлт үйлдүүлэх зардал								
	Бэлгийн тоо	Өрхийн тоо	Үндсэн шалт	НЭШ	Бусад	Хөдөлмөрийн зардал	Ажлын / сууцны төв, өргөтгөл, хөдөлмөрийн зардал	Сургалтын зардал	Сурталчилганы зардал	Төсө / төлөвлөгөө									
Статистийн хэлтэс	1348	10800.0	1188.0	11988.0	960.0	-	-	281.0	3553.0	2810.0	1541.5	928.0	1100.0	-	7800.0	4315.0	4600.0	39678.5	
Сайнцагаан	9	4262			450.0	180.0	2148.4	292.5				80.0	210.0	270	1338.0			4979.9	
Адаацаг	5	813			280.0	50.0	1090.5	162.5				50.0	170.0	150	457.8			2340.8	
Банкергалан	3	408			150.0	30.0	562.7	97.5				30.0	150.0	90	335.9			1448.0	
Говь-Утгал	3	518			150.0	30.0	625.5	97.5				30.0	150.0	90	335.9			1508.8	
Гурвасгайн	5	644			250.0	50.0	920.1	162.5				50.0	170.0	150	457.8			2210.4	
Дэлгэрэнгүй	4	654			200.0	40.0	728.9	130.0				40.0	160.0	120	427.8			1844.7	
Дэлгэрэнгүй	3	517			150.0	30.0	770.4	97.5				30.0	150.0	90	335.9			1653.7	
Дорно	4	583			200.0	40.0	1043.3	130.0				40.0	160.0	120	427.8			2181.1	
Луус	3	533			150.0	30.0	710.4	97.5				30.0	150.0	90	335.9			1583.7	
Өвсийг	6	759			300.0	60.0	1270.3	195.0				60.0	180.0	180	549.6			2795.0	
Өндөршил	2	452			100.0	20.0	627.9	95.0				20.0	140.0	60	335.9			1368.8	
Сайхан-Ойро	4	641			200.0	40.0	775.2	130.0				40.0	160.0	120	427.8			1893.0	
Хулд	4	657			200.0	40.0	1049.9	130.0				40.0	160.0	120	427.8			2158.7	
Цэвэрлэлт	4	354			200.0	40.0	561.7	130.0				40.0	160.0	120	335.9			1617.5	
Эрдэнэдалай	7	1653			350.0	70.0	2964.9	227.5				70.0	190.0	210	731.7			4834.1	
Дүн	66	26896	10800.0	11988.0	4280.0	750.0	15840.0	2145.0	281.0	3553.0	2810.0	1541.5	4588.0	3580.0	1980.0	7800.0	11576.4	4600.0	74072.8

Хянагч: А.Ганбат, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /
Төсвийн хяналтын дарга /
Төсвийн хяналтын дарга /
Төсвийн хяналтын дарга /

Тооллогын хүрээнд аймгийн хэмжээнд 2000 –с дээш хүн амтай Сайнцагаан сумын Нарлаг, Айраг, Арвижих, Мандал багуудад ХАОСТ-ын гэрээт ажилтны сонгон шалгаруулах зар өгөн 12 хүнээс 4 гэрээт ажилтан шалгаруулж аван гэрээ хийж 6 сарын 8-ээс ажилдаа ороод байна. Гэрээт ажилтны сургалтыг 6 сарын 10-ны өдөр хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн нар удирдан зохион байгууллаа. 4 гэрээт ажилтанд ХАОСТ-ын төсвөөс 4 нөтөбүүк, 3 үйлдэлт принтер авч өгөн, мэдээлэл цуглуулах ажилтаны үнэмлэх олгон ажиллуулж байна. Гэрээт ажилтад айлаар нэг бүрчлэн орж мэдээллийг шинэчлэн ажиллыг зохион байгуулж дуусгаад байна.



Төлөвлөгөөний дагуу Аймгийн төвийн 2000-с дээш хүн амтай 4 багийн гэрээт ажилтнууд болон сайнцагаан сумын багийн дарга нарын сургалтын зохион байгуулав.

Сумдын төрийн сангийн мэргэжилтнүүдийн сургалтыг 9 дүгээр сарын 4 нд Хүн ам, орон сууцны завсрын тооллого, анхаарах асуудлууд сэдэвтэйгээр 15-н төрийн сангийн төлөөлөгч нар оролцуулан сургалт зохион байгууллаа.

Багийн Засаг дарга нарын сургалтыг 10 дугаар сарын 30нд Хүн ам, орон сууцны завсрын тооллого, цаашид анхаарах асуудал сэдэвтэйгээр хийж 64 багийн засаг дарга, хамрагдаж амжилттай зохион байгууллаа. Сургалтын төгсгөлд өрх хүн амын алдааг засварлаж аймаг доторх шилжилт хөдөлгөөнийг хийж цэгцэллээ.



Сайнцагаан суман дээр нээлттэй хаалганы өдрийг 10 сарын 20-21ны өдрүүдэд, дэлхийн статистикийн өдөртэй хамтатган зохион байгуулж гэрээт ажилтад болон багийн засаг дарга нар нийт 100 гаруй өрхийн мэдээллийг шинэчлэн ажиллаа. Мөн сум бүр ажлын төлөвлөгөө гарган сургалт сурталчилгааны ажлыг хийж дуусгалаа.



Аймгийн Дундговь ТВ болон Цоглог ТВ-д тооллогын сурталчилгаа шторикийг хүргүүлэн тогтмол гаргаж байна. Мөнпалкат зурагт хуудсыг хэвлэж тараах, урсдаг зараариргэдийг тооллогодоо идэвхтэй хамрагдах талаар зар явуулж байна. Мөн хэлтсийн дарга, Луус сумын багийн засаг дарга Энхбаатар нар Дундговь ТВ-д тооллогын явц, багийн засаг даргын ажлын явцын талаар мэдээлэл өглөө.



Сайнцагаан сумын гэрээт ажилтад ажилсан 4 багийн нийт 42 айлд 10 дугаар сарын 24-26ны өдрүүдэд хяналт хийлээ. Эдгээр 42 айлын 40 хувьд нь буюу 13 өрхөөр нь гэрээт ажилтад орсон, 60 хувь буюу 29 өрхөөр нь ороогүй байна. Тухайн хяналтын ажлын талаархи тайланг хэлтсийн даргад танилцуулан анхаарах асуудлуудыг гэрээт ажилтадад танилцууллаа.

Мөн Хүн ам өрхийн мэдээллийн санд алдаа ихтэй сумдад хэлтсийн мэргэжилтнүүд 2 хэсэг болон ажиллаж нийт 13 суманд ажиллаа



Хаягийн зөрчилтэй 1500 гаруй айлын хаягийг тодруулан дуусгаад байна. ХАОМС-ын програм шинэчлэгдэж байгаатай холбогдуудан бүх сумдуудад суулгах зааварыг хүргүүлэн 12 сарын 1 ны байдлаар 63 баг програмаа бүрэн суулган өрхийн мэдээллээ засварлан хэвийн ажиллаж байна. Зарим сумд интернетээ салгуулсанаас шалтгаалан удаарширч байгааг ярилцан холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Мөн 15 сумаа хэлтсийн 5 мэргэжилтэн тус бүр 3 сум хариуцан авч алдааг яаралтай засварлуулан ажиллаж байна. 11 сарын 6 ны өдөр Сайнцагаан сумын тооллогын комиссын ээлжит хуралд Хэлтсийн дарга Н.Түвшинжаргал, Сайнцагаан сумыг хариуцсан мэргэжилтэн Т.Бямбасүрэн

нар оролцож заавар зөвөлгөө өгч, ХАОМС-ын шинэ хувилбар гарч байгаатай холбогдуудан мэдээлэл хийлээ.

Хүн ам орон сууцны завсрын тооллогын талаар хийсэн ажлын тайланг долоо хоног бүрийн пүрэв гаригт тооллогын товчоонд хүргүүлэн ажиллаа. Тооллогын

явцад БЗД нар шинээр төрсөн хүүхдийг програмд оруулахдаа хүйсийг буруу оруулсаныг тухай бүр МБТГ-ын програмистууд хэлж зөв болголоо. Аймгийн хэмжээнд 6 хүн хоёр өөр регистрээр орсоны 3-г бичиг баримтыг баримтжуулан буруу РД-ыг арилгуулахаар 12 сарын 23 ны өдөр тооллогын товчооны мэргэжилтэн Болор-эрдэнэ болон тооллогын товчоонд хүргүүллээ.

Хүн ам орон сууцны 2015 оны завсрын тооллогын хяналтын тооллогод сонгогдсон Хулд, Адаацаг, Говь-Угтаал, Сайнцагаан сумын 125 өрхөөс судалгааг авч тусгай програмд шивж хугацаанд дамжуулав. Мөн нийт өрхийн байршлыг ХАОМСанд газрын зураг дээр бүрэн тэмдэглэж дуусгалаа. Газрын зураг дээр цэг хатгах явцад 2011 оноос хойш баригдсан барилга, шинэ хашаа газрын зураг тэмдэглэгдээгүй зэрэг хүндрэл байсаныг хариуцсан мэргэжилтэн зөвлөн тухай бүр шийдвэрлэн ажиллаа.

5. БИЗНЕС РЕГИСТРИЙН МЭДЭЭЛЛИЙН САН (Ш5)

Энэ оны эхний байдлаар бизнес регистрийн санд бүртгэлтэй 762 аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагууд байна. Үүнийг үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар авч үзвэл үйл ажиллагаа явуулж байгаа 533, үйл ажиллагаа нь эхлээгүй 55, үйл ажиллагаагаа түр зогсоосон 149, үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон 23, бусад шалтгаантай 2 байгууллага байна.

Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгжийн 69,9 хувь буюу 533 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулдаггүй, эзэн нь өөр аймаг хотод шилжсэн, бүртгэлээс хасах боломжтой нилээд аж ахуйн нэгжүүд байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа 533 байгууллагыг хариуцлагын хэлбэрээр нь авч үзэхэд ХХК - 278, ХК - 6, ББН - 3, ЗБН - 2, хоршоо - 50, ТӨҮГ - 1, ОНӨҮГ-17, төсөвт байгууллага-134, ТББ-42 байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа 533 байгууллагыг өмчийн хэлбэрээр нь авч үзэхэд 2014 онд төрийн 104, хувийн 376, хувийн хамтарсан 1, орон нутгийн өмчийн 57, гадаад улсын 1, нийт 533 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг сумдаар нь авч үзвэл Сайнцагаан суманд 244 буюу 45,8 хувь, Эрдэнэдалай суманд 37 буюу 6,9 хувь нь ногдож байна. Цагаандэлгэр, Дэрэн, Говь-Угтаал, Луус суманд хамгийн бага буюу 12-16 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Дундговь аймагт үйл ажиллагаа явуулж байгаа нийт аж ахуйн нэгж, байгууллагыг ажиллагчдын тооны бүлгээр авч үзвэл, 1-9 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага 408 буюу 76,5 хувь, 10-19 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага 55 буюу 12,7 хувь, 20-49 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага 54 буюу 10,1 хувь, 50-иас дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага 16 буюу 3.0 хувийг бүрдүүлж байна.

Энэ онд сонгогдон ирсэн 120 гаруй аж ахуйн нэгжээс БР-1 маягтаар аж ахуйн үйл ажиллагааны тухай мэдээллийг тодруулан авч програмд оруулан мэдээллийг шинэчиллээ. Сум бүрт бизнес регистрийн санг шинэчлэх талаар албан тоот

хүргүүлж, аж ахуйн нэгж бүрээр бизнес регистрийн санд байгаа ААНБ-ын мэдээллийг тогтмол шинэчилж байна.

Хэлтсийн мэргэжилтнүүд жилд 1 удаа хийдэг БР сангийн тодруулгыг байгууллага бүртэй холбогдон хугацаанд нь тодруулж явууллаа.

ҮСХ-оос тодруулахаар ирсэн сургууль цэцэрлэг, салбар компаниудыг сум бүрээр шалгаж, санд байхгүй байсан 10 гаруй аж ахуйн нэгжийн мэдээллийг шинэчлэн оруулж, бизнес регистрийн санг тогтмол шинэчилэн ажиллаж байна.

II БҮЛЭГ. ТООЛЛОГО, СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

6. МАЛ ТООЛЛОГО (Ш6)

Монгол улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хооронд байгуулсан “Малын индексжүүлсэн даатгал” (МИД) төслийн хүрээнд зохион байгуулж буй хагас жилийн мал тооллогыг 2015 оны 6 сарын 10-аас 6 сарын 17-ны хооронд бүх сумдад амжилттай зохион байгуулав.

2015 оны хагас жилийн мал тооллогын ажлыг хариуцан зохион байгуулж сумдад маягт, заавар, сонгогдсон өрхийн нэрс, программ болон ҮСХ-оос ирсэн албан тоотод үндэслэн хэлтсийн тоот төлөвлөн сумдад хүргүүлж тухай бүрт нь заавар өгч ажиллав. Хагас жилийн мал тооллогод нийт 15 сумын 2464 өрх сонгогдсоноос нийт 2373 өрх хамрагдан 99.9 хувь хамрагдсан. Тухайн жилийн тооллого харьцангуй хүндрэл бэрхшээл багатай байсан.

Тооллогын хяналтыг Хулд, Луус, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан сумдад хийлээ. Хяналтаар ямар нэгэн зөрчил илэрсэнгүй. Тооллогын зардлыг хувиарын дагуу сумдад хувиарлан баримтыг бүрдүүлэн авлаа.


2015 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллогын сургалтыг багийн засаг дарга нарт 2015 оны 10 сарын 30-ны өдөр зохион байгуулж тооллогын маягт, энэ жилийн тооллогын онцлог зэрэг асуудлаар амжилттай зохион байгууллаа.



Аймгийн мал, тэжээвэр амьтдын тооллогын комиссыг аймгийн Засаг даргын 2015 оны 11 сарын 26-ны өдрийн А/496 тоот захирамжаар байгуулж сумдад мал, тооллогын зохион байгуулалтын тухай аймгийн Засаг даргын 2015 оны 11 сарын 30-ны өдрийн 1/1528 тоот албан бичиг хүргүүллээ.

Комиссын хурлыг 2015 оны 12 сарын 1-ний өдөр хийж тооллогын зохион байгуулалт, хяналт хийх удирдамж, чиглэл, бүрэлдэхүүн зэргээ тохирч Аймгийн засаг даргаар батлуулав.

Мал, тэжээвэр амьтдын тооллогын хяналтыг Хүн ам, орон сууцны завсрын тооллогын хяналттай хамтруулан аймгийн Засаг даргаар батлуулсан удирдамж, бүрэлдэхүүний дагуу бүх сумдад 5 хэсэг нийт 20 хүний бүрэлдэхүүнтэй 12 сарын 9-өөс 13-ны өдрүүдэд хийлээ. Хяналтын тооллогоор 15 сумын 90 өрхөөр орж малын тоог тоолж зөрчил гаргасан 2 сумдын тооллогын комисс хариуцлага тооцоор Засаг даргын зөвлөлд оруулахаар төлөвлөж байна.



Мөн сумдад тооллогын комисс байгуулж тооллогыг хуулийн хугацаанд нь зохион байгууллаа.

Мал, тэжээвэр амьтдын тооллогын хяналтыг Хүн ам, орон сууцны завсрын тооллогын хяналттай хамтруулан аймгийн Засаг даргаар батлуулсан удирдамж, бүрэлдэхүүний дагуу бүх сумдад 5 хэсэг нийт 20 хүний бүрэлдэхүүнтэй хийлээ.

7. ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА (Ш7)

Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны судлаач нартай хэлтсийн даргын зүгээс шинээр гэрээ байгуулан, гэрээний дагуу үр дүнг тооцож ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар байдлаар өрхийн нийгэм эдийн засгийн судалгааг 312 өрх сонгогдож нөөц 7 өрх авсан байна. Сар бүр ахлагч судлаачын дамжуулсан өрхийг шалгаж алдааг уншуулан үндэсний статистикийн хороонд дамжуулдаг. Судалгааны хүрээг багийн засаг даргаар тухай бүр нь шинэчлэн Үндэсний статистикийн хороонд хүргүүлж байна. Судалгааг аргачлал зааврын дагуу явуулж, Үндэсний статистикийн хороонд графикт хугацаанд нь мэдээлж, судалгааны чанар, хамралт, үнэн зөвд тавих шаардлагыг өндөржүүлэн хяналтыг сайжруулан судалгааны тоологчдыг өдөр тутмын заавар, зөвлөмжөөр ханган ажиллаж байна.

Оны эхэнд өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааг сумдад шалгах удирдамж, хяналт шалгалтын графикийг гарган энэ дагуу судалгааны ахлагч аймгийн төвд сар бүр 3-5 өрх, сумдад хэлтсийн ажлаар явж байхдаа зарим өрхөөр орж хяналт шалгалтыг тогтмол явуулж байна. Мөн судалгаанд сонгондсон өрхийн утасны

жагсаалтыг тогтмол авч шаардлагтай үед холбоо барьж судалгааг баталгаажуулж байна.

8. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГАА (Ш8)

Эхний хагас жилийн байдлаар ажиллах хүчний судалгааг 480 өрх сонгогдож нөөцөөс 9 өрх авсан байна. Судалгааг Үндэсний статистикийн хороонд явуулах графикт хугацаанд нь дамжуулж, судалгааны чанар, хамралт, үнэн зөвд тавих шаардлагыг өндөржүүлэн хяналтыг сайжруулан судалгааны тоологчдыг өдөр тутмын заавар, зөвлөмжөөр ханган ажиллаж байна.

Ажиллах хүчний судалгааг сумдад шалгах удирдамж, хяналт шалгалтын графикийг гарган энэ дагуу судалгааны ахлагч аймгийн төвд сар бүр 2-3 өрх, сумдад хэлтсийн ажлаар явж байхдаа зарим өрхөөр орж хяналт шалгалтыг тогтмол явуулж байна. Мөн судалгаанд сонгондсон өрхийн утасны жагсаалтыг тогтмол авч шаардлагтай үед холбоо барьж судалгааг баталгаажуулж байна.

III БҮЛЭГ. СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ, СУРГАЛТ,

10. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА (Ш10)

Хэлтсийн даргын баталсан төлөвлөгөөний дагуу хэлтсийн ажилтнууд ажлын байрны сургалтыг 14 хоног дутам зохион байгуулж өөрсдийн мэдлэг чадварыг тогтмол сайжруулан ажиллаж байна.

Мөн хэлтсийн мэргэжилтнүүд 2015 оны жилийн ажлын төлөвлөгөөний сургалт, семинарын нэгдсэн график, төлөвлөгөөг хэлтсийн даргаар батлуулан, батлагдсан төлөвлөгөөний дагуу өөрсдийн хариуцсан сургалтуудыг дараахь байдлаар зохион байгуулаад байна.

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА БАТЛАВ Н.ТҮВШИНЖАРГАЛ						
2015 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРГАЛТ СЕМИНАРЫН НЭГДСЭН ГРАФИК						
д/д	Сургалт семинарын нэр	Оролцох хүн	Хугацаа	Хэд хоног	Оролцох хүний тоо	Зохион байгуулах ажилтан
1	Статистикийн салбарын эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт статистикийн мэдээ, анхан шатны бүртгэл хөтлөх арга зүй	Сум багийн статистикийн мэдээ хариуцсан ажилтнууд	2, 6, 12 сард	6	81	Н.Түвшинжаргал Ажилтнууд
2	Орон нутгийн статистикийн үзүүлэлт, тэдгээрийн бодлого төлөвлөлтөнд ашиглах нь	Орон нутгийн удирдлагууд	4 сарын 17	2	50	Н.Түвшинжаргал Ж.Уянга
3	Статистикийн тухай хууль, бүтэц зохион байгуулалт болон статистикийн тоо, мэдээллийг ашиглах нь	МСҮТ-ийн сурагчид	5,9 сард	2	30	С.Доржханд Т.Бямбасүрэн
4	Статистикийн боловсрол олгох	ЕБС-ийн сурагчид	11 сарын 11	1	35	Н.Түвшинжаргал Ж.Уянга
5	Албан ёсны статистик мэдээний маягт, заавар аргачлал, тоо мэдээллийг хэрхэн ашиглах талаар	ААНБ-ын ня-бо нар	6, 12 сард	2	50	Ж.Уянга Ажилтнууд
6	Статистикийн мэдээллийг хэрхэн ашиглах, мал тооллого зохион байгуулах талаар	Сумдын удирдлага, түшмэлүүд	6, 12 сард	2	50	Н.Түвшинжаргал Ажилтнууд
7	Даймгийн нийгэм, эдийн засгийн байдал, статистикийн мэдээллийг хэрхэн ашиглах, талаар	Албан газрын удирдлага, ажилтнууд	1, 4, 7, 10 сард	4	50	Н.Түвшинжаргал Ажилтнууд
8	2015 оны завсрын тоолого явуулах тухай	Сум багийн статистикийн мэдээ хариуцсан ажилтнууд	жилдээ	2	81	Н.Түвшинжаргал Ажилтнууд

1. Сумдын төрийн сангийн мэргэжилтнүүдийн сургалт /БХСС/

Сумдын төрийн сангийн мэргэжилтнүүдийн сургалтыг 2015 оны 02 сарын 12 мөн 9 сарын 9 ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Эхний сургалтаар манай аймагт энэ оны 3 сарын 1-ээс статистик мэдээг төрийн сангийн мэргэжилтнүүд хариуцах болсонтой холбогдуулан ҮСХ-оос өгсөн сургалтын дагуу бэлдсэн хичээлийг зааж мөн хэлтсээс статистикийн салбарын өнөөгийн байдал болоод цаашид анхаарах

асуудал, ХАӨМС-ийн заавар, жилийн эцсийн мэдээний хүрээ, маягт, статистик мэдээллийн нэгдсэн сангийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийж статистикийн салбарыг 2016-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, статистикийн салбарын 2015 оны төлөвлөгөөнд тусгасан орон нутгийн холбоотой ажил, үйлчилгээ, орон нутгийн түвшинд тооцох статистикийн үзүүлэлтүүд, хүн ам, өрхийн мэдээллийн сан, мал тооллогын онлайн систем түүний ашиглалт, тооллогын чанар, зохион байгуулалт, орон нутаг 2015 онд зохион байгуулах тооллого, судалгаа, хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллого г.мэт мэдээллийг хүргэсэн. Сургалтанд 15 сумын 15 төрийн сангийн мэргэжилтнүүд оролцсон.



Мөн уг сургалтаар нийт 15 сумын 66 багийн дарга нарын компьютерт антивирусын програм суулгах талаар төрийн сангийн төлөөлөгч нарт антивирус програм сунгах, ашиглах талаар сургалт зохион байгуулсан.

9 сарын 9 ны сургалтанд 15 сумын мэргэжилтнүүд бүрэн хамрагдсан бөгөөд аймгийн төвд ажиллаж байгаа ХАОС-ны завсрын тооллогын гэрээт ажилтнууд мөн хамрагдлаа.



Энэ удаагийн сургалтаар “Хүн ам, орон сууцны завсрын тооллого, анхаарах асуудал” сэдвийн дор голчлон ярилцсан бөгөөд мөн статистик мэдээний ирц, чанар, ӨНЭЗС болон АХС-ны үр дүнгийн танилцуулга, Статистикийн товчоон номын танилцуулга, статистик мэдээллийн нэгдсэн сангийн хэрэглээ зэрэг сэдвүүдийг багтаалаа.

Сургалтанд оролцогчдод сургалтын хөтөлбөр, сургалтын хүрээнд хийх илтгэлүүд, хууль эрх зүйн эвхмэл, статистик мэдээллийн нэгдсэн сангийн сурталчилгааны хуудас зэрэг материал тараалаа.

Сургалтын төгсгөлд оролцогчдоос тухайн өдрийн сургалтын талаар санал хүсэлтийн хуудас бөглүүлж цаашид сургалтын үйл ажиллагаанд анхаарч ажиллахаар төлөвлөж байна.

2. Бизнесийн салбарын нягтлан бодогч нарт зориулсан сургалтын тайлан /БСС/

Аж ахуйн нэгжийн нягтлан бодогч нарт зориулсан сургалтыг 2 удаа зохион байгууллаа. Сургалтыг Статистикийн хэлтсийн дарга Н.Түвшинжаргал нээж, ахлах мэргэжилтэн Ж.Уянга удирдан явуулсан.

Сургалтын хөтөлбөр статистикийн хэлтсийн бүтэц зохион байгуулалт, ажилчдын танилцуулга, Статистикийн тухай ерөнхий ойлголт, Статистикийн ажилтай холбогдолтой хууль эрхийн актууд, статистик мэдээний график, мэдээ, тайлан гаргахад анхаарах асуудлууд, нийгмийн даатгалын сангийн анхан шатны бүртгэлийг сайжруулах талаар, статистик мэдээ, мэдээллийг хаанаас авах, статистик мэдээллийн нэгдсэн сангийн тухай, жилийн эцсийн мэдээний маягтын заавар, хэлтсийн дотоод мэдээлэл зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгууллаа. Сургалтанд нийт давхардсан тоогоор 72 аж ахуй нэгжийн 65 нягтлан хамрагдлаа.

Сургалтын үеэр сургалтын хөтөлбөр, заасан хичээл болон ААН-1, ААН-2 маягт, хэлтсээс гаргасан статистикийн тухай хууль, статистик тоо, мэдээлэл агуулсан нугалбар зэргийг оролцогч нарт тараалаа.



3. МСҮТ-ийн оюутнуудад хийсэн “Статистикийн тухай мэдлэг, мэдээлэл” сэдэвт сургалтын тайлан /ИДСС/


Статистикийн хэлтсээс жил бүр зохион байгуулдаг аймгийн МСҮТ-ийн оюутнуудад зориулсан сургалтыг 2 удаа “Статистикийн тухай мэдлэг, мэдээлэл” сэдвийн хүрээнд хийсэн.

Сургалтыг тус коллежийн барилгын дотоод засал чимэглэл, тогооч нарийн боов, оёдол эсгүүрийн төгсөх курсийн оюутнуудыг хамруулан явууллаа. Уг сургалтыг Статистикийн хэлтсийн Аж үйлдвэр худалдаа хариуцсан мэргэжилтэн Т.Бямбасүрэн Хүн ам хариуцсан мэргэжилтэн С.Доржханд, ахлах мэргэжилтэн Ж.Уянга нар удирдан зохион байгууллаа.

Сургалтанд хамрагдсан оюутнууд хэрэгцээтэй мэддэггүй зүйлсээ мэдэж авсан тухайгаа санал асуулгад илэрхийлсэн байна. Мөн сургалтанд оролцсон нийт оюутнуудад заасан хичээл болон 2014 оны жилийн эцсийн мэдээ, энэ оны 3 р улирлын мэдээллийг хамруулан статистик мэдээллийн нугалбарыг оюутнуудад тараалаа.



Мөн 2015 оны 10 сарын 20-ны өдөр буюу “Дэлхийн статистикийн өдөр” –ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Ерөнхий боловсролын Хүмүүнлэг сургуулийн төгсөх ангийн сурагчдад “Статистикийн боловсрол” сэдвээр хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Уянга хичээл заалаа. Мөн АХА тэмцээн зохион байгуулж 12а ангийн сурагч Оюун-эрдэнэ 1-р байр, 12а ангийн сурагч Ундрах 2-р байр, 12б ангийн сурагч Буян-Арвижих 3 байрыг тус тус эзэллээ. Байр эзэлсэн сурагчдад Статистикийн хэлтсийн нэрийн шагнал гардууллаа.



4. “Орон нутгийн статистикийн үзүүлэлт, тэдгээрийг бодлого, төлөвлөлтөнд ашиглах нь” сэдэвт сургалт

Дундговь аймгийн Статистикийн хэлтсээс 2015 оны 4 сарын 17-ны өдөр аймгийн хэлтэс, агентлагын дарга, ахлах мэргэжилтнүүдэд “ОРОН НУТГИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ТЭДГЭЭРИЙГ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТӨД АШИГЛАХ НЬ” сэдэвт сургалтыг ҮСХ-ны МЭЗГ-н Үндэсний тооцооны хэлтсийн дарга Б.Баярмаатай хамтран зохион байгуулсан.

Уг сургалтанд Аймгийн засаг даргын тамгын газрын дарга П.Бямбалхагва болон аймгийн төвийн байгууллагууд, хэлтэс агентлагуудын удирдлагууд нийт 50 хүн оролцож сургалтын ирц, хамрагдалт, идэвхи оролцоо хангалттай сайн байсан билээ.

Сургалт хөтөлбөрийн дагуу “Сургалтын зорилго, Статистикийн үзүүлэлтийг орон нутгийн бодлого, төлөвлөлт, хяналт, шинжилгээнд ашиглах хэрэгцээ, ач холбогдол”, “Орон нутгийн түвшинд тооцох статистикийн үзүүлэлтийн хүрээ”, “МУ-ын Засгийн газрын 2014 оны 242 тоот тогтоол “Сумын хөгжлийн индекс тооцох аргачлал”, холбогдох үзүүлэлтүүд”, “Эдийн засгийн статистикийн үзүүлэлтийг орон нутгийн түвшинд тооцох, бодлого, төлөвлөлт, хяналт үнэлгээ, шинжилгээ хийхэд ашиглах нь”, “Орон нутгийн түвшинд тооцох хүн ам, нийгмийн статистикийн үзүүлэлтийн хүрээ, ойлголт, тодорхойлолт, тэдгээрийг бодлого, төлөвлөлт, хяналт үнэлгээ, шинжилгээ хийхэд ашиглах нь”, “Статистикийн мэдээллээр үйлчлэх сангийн хэрэглээ, ашиглалт www.1212.mn, Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн хэрэглээ, түүний ашиглалт”, сэдвүүдийн хүрээнд ҮТХэлтсийн дарга Б.Баярмаа, хэлтсийн дарга Н.Түвшинжаргал, ахлах мэргэжилтэн Ж.Уянга нар хичээл заалаа.

Мөн ҮТХэлтсийн дарга Б.Баярмаа, хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Уянга нар сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга нар нийт 15 хүнд Статистикийн товчоон номын тухай, ойлголт, эдийн засгийн болон нийгмийн салбарын үзүүлэлтийн талаарх ойлголт тодорхойлолт, сумын хөгжлийн индекс тооцоход шаардлагатай үзүүлэлтүүдийн талаар товчхон мэдээлэл хийж сонирхсон асуултанд хариулт өгсөн.

Тус хэлтсээс зохион байгуулсан “ОРОН НУТГИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ТЭДГЭЭРИЙГ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТӨД АШИГЛАХ НЬ” сэдэвт сургалт цаг үеэ олсон, орон нутгийн удирдлагуудын хэрэгцээнд нийцсэн, ач холбогдолтой, үр дүнтэй сургалт болсон билээ.



Сургалтын дараа тус сургалттай холбоотой санал, хүсэлтийн хуудас бөглүүлж авсан бөгөөд тэдгээрийн нэгтгэхэд дараах санал, хүсэлт, дүгнэлт, шүүмжлэл гарлаа. Үүнд:

1. Сургалтын хөтөлбөр, агуулга цаг үеэ олсон хэрэгцээтэй байсан.
2. Сум, багийн анхан шатны мэдээлэгч нарт энэ хөтөлбөрөөр хичээл орох
3. Цаашид Статистикийн товчоон номыг жил бүр гаргаж байх
4. Зохион байгуулалтыг илүү сайжруулах
5. Дундговь аймгийн хувьд хүн амын тоон дээр нэг ойлголтод хүрэх. Жишээ нь суурин хүн амаар 44,4 мянган хүнтэй байхад Статистикийн жилийн эмхтгэл,

Статистикийн товчоон ном дээр 37,0 мянган хүн байгаа нь хэрэглэгчдэд ойлгомжгүй байна

6. Статистик мэдээ, мэдээллийг иргэдэд илүү сурталчилах шаардлагатай

7. Энэ хичээл дээр гарч байгаа шиг аймаг, сум багийн түвшингийн үзүүлэлтийг илүү дэлгэрэнгүй, олон төрлийн мэдээлэл гаргадаг болох

8. Сургалт цаг үеэ олсон, ач холбогдолтой, үр дүн сайтай боллоо гэх мэт олон санал, хүсэлт байлаа. Нэгтгэж дүгнэхэд сургалтанд оролцогчдын 50 хувь нь хангалттай, 25 хувь сайн, 25 хувь нь сайжруулах шаардлагатай гэж үнэлгээ өглөө. Цаашид хэлтсийн үйл ажиллагаа болон ямар нэг сургалт, сурталчилгаа хийхэд анхаарах асуудал байна гэж ойлгож байна.

5. Сумдын Багийн засаг дарга нарт зориулсан сургалтын тайлан

Дундговь аймгийн Статистикийн хэлтэс нь 2015 оны төлөвлөгөөний дагуу анхан шатны статистик мэдээ хариуцсан ажилтнууд буюу багийн засаг дарга нарт зориулсан сургалтыг 2015 оны 10 сарын 30-ны өдөр амжилттай зохион байгууллаа.

Сургалтыг аймгийн Засаг дарга С.Од-Эрдэнэ болон хэлтсийн дарга Н.Түвшинжаргал нар нээж, Статистикийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Ж.Уянга, мэргэжилтэн С.Доржханд, мэргэжилтэн Т.Бямбасүрэн нар хичээл заалаа.



Уг сургалтанд:

1. Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогын зохион байгуулалт, явц
2. ХАӨМС-ийн мэдээллийн шинэчлэхэд хяналт тавих, анхаарах асуудал
3. Статистикийн товчоон номын танилцуулга
4. Статистик мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn танилцуулга болон түүний хэрэглээ
5. Жилийн эцсийн мал тооллогын зохион байгуулалт, анхаарах асуудал
6. Статистикийн тухай хууль болон багийн Засаг дарга нарт холбогдолтой бусад хуулийн заалтууд
7. Цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээлэл сэдвүүдээр бүтэн өдрийн сургалт хийлээ.

Сургалтанд 62 багийн дарга буюу 93.9 хувь, Сайнцагаан сумын багийн засаг дарга нарын туслах 3 хүн нийт 65 хүн оролцлоо.

Сургалтын сүүлийн хэсэгт ХАӨМСангийн алдааг баг бүр засч мөн аймаг доторх шилжилт хөдөлгөөнөө ярилцан баталж нэг мөр болгон цэгцэлсэн нь Хүн ам, орон сууцны завсрын тооллогын ажилд ихээхэн ахиж гарлаа.

Сургалтын төгсгөлд сургалтанд оролцогсдоос сургалтын явц, чанар, сургалтын агуулга, цаашид хийх сургалтын талаар санал асуулга авч нэгтгэлээ. Уг саналыг дүгнэвэл:

1. Сургалт цаг үеэ олсон чанартай сургалт боллоо
2. Багийн засаг дарга нарын сургалтын жилд 2-3 удаа зохион байгуулж байх
3. Улсын хэмжээнд бүсчилсэн сургалт хийх
4. Багийн засаг дарга нарт улирал тутам шатахуун болон утасны зардал шийдэж өгөх (сумаас өгөхөө больсон)
5. Зарим сумдад интернэтийн сүлжээ болон төлбөрийн асуудал хүндрэлтэй байгааг харгалзан боломжоороо туслах (модем гэх мэт зүйлээр)
6. Улаанбаатар хотын зарим хороо шилжилт хөдөлгөөнөө батлахгүй удах мөн албан ёсоор шилжээгүй хүнийг бүртгэж авах асуудал гарч байгаа
7. Зуны улиралд аялал зугаалгаар явах гэсэн саналууд дийлэнх гарч байна.

6. ЕБС-ын сурагчдад статистикийн боловсрол олгох сургалт

Монгол Улсад Статистикийн алба үүсэн байгуулагдсаны 91 жилийн ойг тохиолдуулан Дундговь аймгийн Сайнцагаан сумын 3-р сургуулийн 106 ангийн сурагчдад “Статистикийн боловсрол олгох” сэдвээр хичээлийг 2015 оны 11 сарын 11 ны өдөр зааж, сурагчдын асуусан асуултанд мэдээлэл өгч, харилцан ярилцлаа.



Мөн Статистикийн албаны өдрийг тохиолдуулан “Ажилчдын Гэр бүлийн өдөрлөг”-ийг жил бүр уламжлал болгон зохион байгуулахаар хэлтсийн ажилчид санал гаргасаны дагуу гэр бүлийн өдөрлөгийг “Ажлын эрч хүчийг Гэр бүлээс” уриатайгаар зохион байгуулж, өдөрлөгийн үеэр гар бөмбөг болон чанга шивнээ тэмцээнийг тус тус зохион байгуулан явуулж, гар бөмбөгийн тэмцээнд 3 баг, чанга шивнээнд гэр бүлээрээ оролцлоо. Гар бөмбөгийн тэмцээнд нийт 3 баг оролцож, Баттүвшин ахлагчтай Хар бухнууд баг 1-р байр, Эрдэнэ-Очир ахлагчтай “Улаан шонхорууд” баг 2-р байр, Н.Түвшинжаргал ахлагчтай “Бид чадна” баг 3-р байрыг тус тус эзэлж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагналаа. Чанга шивнээ тэмцээний төрөлд хэлтсийн гэрээт ажилтан Ц.Урансайханы гэр бүл түрүүлж, дурсамж, дурсгалын зүйл хадгалуулав.

Гэр бүлийн өдөрлөгөөр ажилчдын гэр бүлүүд танилцаж, нэгэн өдрийг спортлог, оюунлаг хөгжөөнт уралдаан тэмцээнд оролцож “Гэр бүл”-н өдрийг хамтдаа тэмдэглэн өнгөрүүлээ.



Манай хэлтсээс энэ оны байдлаар нийт 13 удаагийн сургалтыг зохион байгуулж, аймгийн хэмжээний байгууллагуудын удирдлагууд, багийн дарга нар, төрийн сангийн мэргэжилтнүүдээс бүрдсэн 111 хүн, ААН байгууллагуудын 65 хүн, оюутан, сурагчдаас бүрдсэн 106 хүн нийт 282 хүнийг хамруулсан байна. Сургалтуудын тайланг сургалт зохион байгуулсан өдрөөс хойш 5 хоногийн дотор ҮСХ-нд явуулж хэвшээд байна.

Хэлтсийн мэргэжилтнүүдээс нярав Г.Баясгалан аймгийн төрийн сангаас зохион байгуулсан төсвийн байгууллагууд болон ААН байгууллагуудын няравуудад зориулсан 2 өдрийн сургалтанд, Ахлах мэргэжилтэн Ш. Уянга АЗДТГ-ын ТЗУХ-ийн

ХШҮ-ний тасгаас зохион байгуулсан дотоод ХШҮ-г хэрхэн хийх талаарх сургалт болон хүүхдийн байгууллагаас зохион байгуулсан сургалтанд, Хэлтсийн дарга Н.Түвшинжаргал, мэргэжилтэн Энхтуяа нар байгууллагуудын залуучуудын зөвлөлийн дарга, гишүүд хамрагдсан “Хариуцлагатай залуу манлайлагч” сургалтанд тус тус хамрагдсан болно.


СУРТАЛЧИЛГАА (Ш11)

1. Хэвлэлийн бага хурал /ХБХ/

Дундговь аймгийн Статистикийн хэлтсийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон сурталчилгааны ажлын батлагдсан төлөвлөгөөний дагуу сар бүрийн Аймгийн нийгэм, эдийн засгийн танилцуулгаар иргэдэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон танхимаар мэдээлэл байнга өгч байгаа билээ. Аймгийн нийгэм, эдийн засгийн гол үзүүлэлтүүдээр танилцуулгыг бэлтгэж дараа сарын 10 ны дотор хэвлэж, нийт хэвлэмэл байдлаар сар бүр 12 ширхэгийг хэвлэж, аймгийн удирдлага, хэлтэс агентлагийн дарга нарт танилцуулахын зэрэгцээ сар бүрийн 15-ны дотор 11.00 цагаас аймгийн Засаг даргын тамгын газрын телевиз, Дундговийн амьдрал сонин, TV-9 телевизийн орон нутаг дах сэтгүүлч, аймгийн ЗДТГ-н хэлтсүүдийн бие төлөөлөгч нарт Аймгийн нийгэм, эдийн засгийн гол үзүүлэлтүүдээр хэвлэлийн бага хурал, танилцуулга бэлтгэж танилцуулж хэвшсэн.

Хэвлэлийн бага хурлуудаас илүү онцлог болсон нь 1 сарын хурал байсан. 1 сарын хэвлэлийн хурлыг 2 сарын 10-ний өдрийн 11 цагт хийсэн бөгөөд мөн нэмэлтээр 2014 оны жилийн эцсийн мэдээ болон 2015 оны 1 сарын аймгийн нийгэм эдийн засгийн мэдээллээр танилцуулгыг Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн 2015 оны 2 сарын 24-ны өдрийн хуралдааны үеэр хийж нийт 33 хурлын төлөөлөгчдөд мэдээлэл хүргэж, 2014 оны 12 сар, 2015 оны 01 сарын танилцуулгаа тараалаа. Тус хэлтсээс жил бүр заавал гаргадаг танилцуулгууд болох Өрх хүн амын танилцуулга, Хөдөө аж ахуйн танилцуулга, Аж үйлдвэр үйлчилгээний салбарын танилцуулга, Ажил эрхлэлтийн танилцуулгын олон нийтэд мэдээлэх ажлыг 3, 4, 5, 6 сарын хэвлэлийн хуралтай хамтатган хийсэн нь хүмүүсээс таралхал хүлээсэн ажил болсон юм.





2015 оны хувьд хэвлэлийн бага хурлыг өмнөх оны эцсийн болон 2015 оны бүх саруудаар нийт 12 удаа хийж, 210 ширхэг танилцуулгыг тархааж, сар бүрийн танилцуулга болон хэвлэлийн хурлын материалыг web-д байршуулж ажиллаа.

2. Тооллого судалгааны сурталчилгаа

ҮСХ-ноос тухайн жилд зохион байгуулж байгаа тооллого, судалгааны талаар улирал тутам мэдээлэл бэлтгэж сурталчлах ажлыг оны эхэнд хэлтсийн даргын баталсан сурталчилгааны ажлын төлөвлөгөөний дагуу болон цаг үеийн нэмэлт сурталчилгааны ажлуудыг 2015 онд зохион байгуулсан байна.

Хэлтсийн даргын баталсан төлөвлөгөөний дагуу 1-р улиралд Ажиллах хүчний судалгааны танилцуулга, 2-р улиралд Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны үр дүнгийн танилцуулга, 3 болон 4-р улиралд 2015 оны хүн ам орон сууцны завсрын тооллогын сурталчилгаа мэдээллийн ажлууд хийгдсэн юм. Өрхөд суурилсан НЭ ЗС-ны тайлан мэдээлэл сурталчилгааны ажлыг судлаач Ж.Мөнхбаяр, Г.Болормаа хэлтсийн дарга Н.Түвшинжаргал нар хариуцан хэлтсийн нийт ажилтнууд зохион байгуулан аймгийн ЗДТГ-ын хэлтсийн төлөөллүүд, Хөдөлмөр болон Халамж үйлчилгээний хэлтсийн ажилтнууд, сумдын төрийн сангийн мэргэжилтнүүд бусад сонирхсон хүмүүс хамрагдсан юм.



Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллого явагдаж байгаатай холбогдуулан тооллогын сурталчилгааны ажлыг оны сүүлийн хагаст идэвхжүүлж ажиллаа.

Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллого явагдаж байгаатай холбогдуулан аймгийн төвийн 2000-аас дээш хүн амтай 4 багт 6 сарын хугацаатай 4 гэрээт ажилтан авч ажиллуулж байгаа билээ.

Тэдгээр гэрээт ажилчдад зориулсан сургалтыг 2015 оны 6 сарын 8-ны өдөр зохион байгууллаа. Сургалтыг Статистикийн хэлтсийн дарга Н.Түвшинжаргал нээж,

ахлах мэргэжилтэн Ж.Уянга удирдан явууллаа. Сургалтанд Сайнцагаан сумын 7 багийн дарга, 5 нийгмийн ажилтан, 4 гэрээт ажилтан нийт 16 хүн хамрагдлаа.

Сургалтын хөтөлбөр статитикийн хэлтсийн бүтэц зохион байгуулалт, ажилчдын танилцуулга, Статистикийн тухай ерөнхий ойлголт, Статистикийн тухай хуулиас, статистик мэдээ, мэдээллийг хаанаас авах, статистик мэдээллийн нэгдсэн сангийн тухай, хэлтсийн дотоод мэдээлэл, Хүн ам, орон сууцны завсрын тооллогын тухай ойлголт зэрэг сэдвийг агуулсан 1 дүгээр хэсэг, ХАӨМСан, түүний хэрэглээ, програмын заавар гэсэн 2 дугаар хэсгээс бүрдлээ.

Сургалтын үеэр сургалтын хөтөлбөр, заасан хичээл болон ХАӨМСангийн програмын зааварын ном, хэлтсээс гаргасан статистикийн тухай хууль, статистик тоо, мэдээлэл агуулсан нугалбар, гэрээт ажилтны үнэмлэх, ХАОСТОоллогын цүнх зэргийг оролцогч нарт тараалаа.



2015 оны Хүн ам орон сууцны завсрын тооллогын ажлын явцыг идэвхжүүлж иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн төвийн сум болох Сайнцагаан суманд нээлттэй хаалганы өдөрлөгийг 2015 оны 10 сарын 20-ны өдөр зохион байгууллаа. Энэ үйл ажиллагааг 7 хоногийн өмнөөс орон нутгийн Цоглог болон Дундговь телевизороор сурталчлан зарлаж явуулсан юм.

Тус өдөрлөг Сайнцагаан сумын Иргэний танхимд болсон бөгөөд үйл ажиллагааг дундговь аймгийн статистикийн хэлтсийн хамт олон, Сайнцагаан сумын Хүн ам орон сууцны завсрын тооллогын комисс, тооллогын гэрээт ажилтнууд хамтран амжилттай зохион байгуулсан юм. Өдөрлөгийн хүрээнд аймгийн төвийн нийт 150 хүн өөрийн гэр бүлийн мэдээллийг шинэчлэхээр хандаж нийт 150 өрхийн мэдээллийг баталгаажуулсан юм.



Хэрэглэгчдэд статистикийн мэдээллийн санг сурталчлах /ХСМСС/

Тус хэлтэс 2015 онд статистик мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn МонСтат, EzStat аппликейшнийг хэрэглэгчдэд сурталчлах ажлыг нийт 12 удаа сар бүрийн хэвлэлийн бага хуралтай хамтатган аймгийн Засаг даргын тамгын газрын телевиз, Дундговийн амьдрал сонин, TV-9 телевизийн орон нутаг дах сэтгүүлч нарт болон хэвлэлийн бага хуралд оролцсон Аймгийн ЗДТГ-ын болон бусад хэлтэс,

агентлагуудын удирдлагуудад хийсэн байна. Мөн аймгийн вэб хуудас, фэйсбүүк, Дундговь аймгийн байгууллагын цогц мэдээлэл /и-оффисс/ зэргээр олон нийтэд сурталчилж байна.

Аймгийн иргэдийн хурлаас зохион байгуулсан ИРГЭДИЙН ОРОЛЦОО, ХӨГЖЛИЙН БОДЛОГО олон Улсын анхдугаар симпозиумд 2015 оны жилийн эцсийн инфографикийг 100 хувь хэвлэж тархаасан.



3. Хууль болон салбарын үйл ажиллагааг сурталчлах – ХБСҮАС

Тус хэлтсээс 2015 онд статистикийн хууль болон салбарын үйл ажиллагааг сурталчлах үйл ажиллагааг олон удаа зохион байгуулсан байна.

2015 оны 03 сарын 27-нд Дундговь аймаг дахь Монгол банкны салбараас санаачлан "Санхүү эдийн засгийн хамтын ажиллагаа" сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт Дундговь аймаг дахь Монгол банкны салбар, Дундговь аймгийн Статистикийн хэлтэс, Дундговь аймгийн Татварын хэлтэс, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар оролцож, оролцогч байгууллагууд өөрсдийн байгууллагын танилцуулгыг тавьж улмаар цаашид хэрхэн хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа танилцуулсан юм. Хэлэлцүүлэгт тус хэлтсийн дарга Н.Түвшинжаргал, худалдаа аж үйлдвэр хариуцсан мэргэжилтэн Т.Бямбасүрэн нар оролцож Статистикийн тухай хууль болон хэлтсийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан сарын танилцуулга болон хэвлэмэл нугалбар тараасан юм.

2015 оны 4 сарын 18-нд аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан сумдын ИТХ-ын дарга нар болон нарийн бичгийн дарга нарын сургалтанд хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж. Уянга, ҮСХ-ы ҮТХ-н дарга Б.Баярмаа болон хэлтсийн аж үйлдвэр худалдаа хариуцсан мэргэжилтэн Т.Бямбасүрэн нар оролцож хэлтсийн үйл ажиллагааг танилцуулж, мэдээ мэдээлэл өгч ажилласан юм.



2015 оны байдлаар тус хэлтсээс 2015 онд нийт 12 удаагийн сургалт, сурталчилгааг зохион байгуулж, аймгийн хэмжээний байгууллагуудын удирдлагууд, багийн дарга нар, төрийн сангийн мэргэжилтнүүдээс бүрдсэн 96 хүн, ААН байгууллагуудын 33 хүн, оюутнуудаас бүрдсэн 30 хүн, сумдын орлогч дарга нийт 15 сурталчилгаагаар Аймгийн иргэдийн хурлын нийт 33, төлөөлөгчид нийт 342 хүнд танхимаар статистикийн тухай ерөнхий ойлголт, бүтэц зохион байгуулалт, статистикийн тухай хуулиас, статистик мэдээ мэдээлэлийг хэрхэн хэрэглэгчдэд тархаадаг тухай, статистик мэдээ, мэдээллийг хаанаас авах, статистик мэдээллийн

нэгдсэн сан www.1212.mn-ий тухай EZstat Монстат апплекешний талаар дэлгэрэнгүй мэдээлэлийг өгсөн байна.

2015 оны орон нутгийн телевиз, фэсбүүкийн шилдэг мэдээлэгч байгуулага болж бүтэн жил үнэгүй ашиглах Gmobile-н модемоор шагнуулж амжилттай ажиллаа. Энэ модем нь сүүлийн үеийн 5 компьютерт WIFI цацдаг хаана ч ашиглах боломжтой юм.



12. ВЭБ БАЯЖИЛТ (Ш12)

Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль болон Стандартчилын үндэсний зөвлөлийн 2011 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага”-ын дагуу байгууллагын нэр, лого, эрхэм зорилго, байгууллагын үйл ажиллагааны стратеги зорилго, бүтэц зохион байгуулалт, байгууллагын үйл ажиллагаан дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, тухайн жилийн төсвийн төлөвлөгөө , сарын мэдээ, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, шинэ мэдээ, мэдээлэл, хаяг байршил, статистик мэдээ, холбогдох холбоос, зургийн цомог зэргийг байршуулан ажиллаж байна.

ДУНДГОВЬ

Дундговь аймгийн статистикийн хэлтэс

Танилцуулга Шинэ мэдээлэл Хууль, тогтоомж Биопленте, танилцуулга Нийгэм, эдийн засгийн мэдээлэл Тоололо Ил тод байдал Шилэн данс Харилцах хаяг

2015 оны 11 сарын аймгийн нийгэм, эдийн засгийн танилцуулгын хэвлэлийн хурал хийлээ.

Нийтэлсэн: 2015 он 12 сар 11, 12 цаг 50 минут

Төсвийн орлого Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээгээр 2015 оны 11-р сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 118.3 хувьтай буюу 4073.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүний гадна улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 141.8 хувьтай буюу 2378.8 сая төгрөгийн орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулаад байна. Улсын болон орон нутгийн төсөвт нийт дүнгээр 6449.8 сая төгрөгийн орлого оруулж, аймгийн дүнгээр орлогын төлөвлөгөөний биелэлт 128 хувьтай байна. Тусламжийн орлогыг оруулан тооцсоноор аймгийн хэмжээний нийт орлого ба тусламж 32785.1 сая төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 97.1 хувьтай байна. Орон нутгийн төсөвт улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг 6931.2 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 18641.8 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээс 3119 саятөг нийт 28692 сая төгрөгийн тусламжийн орлого орсон байна.

[Дэлгэрэнгүй](#)

Аймгийн нийгэм, эдийн засгийн 11 сарын танилцуулга гарлаа.

Нийтэлсэн: 2015 он 12 сар 11, 12 цаг 11 минут

Төсвийн орлого Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээгээр 2015 оны 11-р сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 118.3 хувьтай буюу 4073.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүний гадна улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 141.8 хувьтай буюу 2378.8 сая төгрөгийн орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулаад байна. Улсын болон орон нутгийн төсөвт нийт дүнгээр 6449.8 сая төгрөгийн орлого оруулж, аймгийн дүнгээр орлогын төлөвлөгөөний биелэлт 128 хувьтай байна. Тусламжийн орлогыг оруулан тооцсоноор аймгийн хэмжээний нийт орлого ба тусламж 32785.1 сая төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 97.1 хувьтай байна. Орон нутгийн төсөвт улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг 6931.2 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 18641.8 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээс 3119 саятөг нийт 28692 сая төгрөгийн тусламжийн орлого орсон байна.

Иргэн Та хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллээ шалгах баталгаажуулна уу

Гадаадад 183 хоногос дээш хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэд интернет тооллогод хамрагдана уу

ТУСЛАХ ЦЭС

- Мэдээний маягт
- Программ хангамж
- Албан бичиг

Аймгийн dev-info мэдээллийн санд бүх салбарын гол үзүүлэлтүүдээр аймгийн дүн болон сумаар олон жилийн динамик бүрдүүлж вэб-д оруулаад байна. Мөн аймгийн нийгэм эдийн засгийн танилцуулгыг сар бүр тогтмол оруулдаг, Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга, хүн ам, өрхийн үндсэн үзүүлэлтүүдийн төлөв, байдлын танилцуулга, хүн амын ажил эрхлэлт, ажилгүйдлийн танилцуулга, аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын танилцуулга зэргийг байршуулаад байна.

Хэлтсийн вэб хуудсыг шинэчилж аймгийн нийгэм эдийн засгийн 1-5- р сарын танилцуулга болон хэвлэлийн бага хурал хийсэн персентацийг хэлтсийн вэб-д

Динамик хүснэгт

ДИНАМИК СУДАЛГАА

Динамик судалгааны нэр	Түвшин	Он	Мэдээлэл авах
Хүн амын тоо / өрх хүн амын зарим үзүүлэлт /	Сумаар	1996-2014	Татах
Малын тоо, / төл бойжилт, хээлтэгч, малын зүй бус хоргодол /	Сумаар	1980-2014	Татах
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	Аймгаар	1997-2014	Татах
Бүртгэлтэй ажилгүйчүүд	Аймгаар	2001-2014	Татах
Эрүүл мэнд	Сумаар	1989-2014	Татах
Нийгмийн даатгал	Сумаар	2007-2014	Татах
Газар тариалан	Сумаар	2001-2014	Татах
Барилга	Аймгаар	2006-2014	Татах

[Дэлгэрэнгүй мэдээлэл авах.](#)

тогтмол байршуулдаг боллоо. Мөн ХАА-н танилцуулга болон хүн ам, өрхийн үндсэн үзүүлэлтүүдийн төлөв, байдлын танилцуулгыг 4 сард, хүн амын ажил эрхлэлт, ажилгүйдлын танилцуулгыг 5 сард, аж үйлдвэр, барилгын салбарын танилцуулгыг 6 сард вэб-д байршууллаа.



13. МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ (Ш13)

Аймгийн нийгэм эдийн засгийн танилцуулгыг сар бүрийн 10-нд аймгийн Иргэдийн хурлын дарга, Засаг дарга, Засаг даргын тамгын газрын дарга, Хэлтсийн дарга нарт 12 хувь хэвлэн тархаадаг ба 2015 онд нийт 132 ширхэгийг тархааж бусад агентлагын дарга болон аж ахуй нэгж иргэдэд мэйл хаягаар өгч байна. Сарын бүрийн танилцуугаар хэвлэлийн бага хурлыг тогтмол зохион байгуулж, орон нутгийн сонины сэтгүүлч, олон нийттэй харилцах албаны мэргэжилтэн бусад газар агентлагуудаас төлөөлөлүүд оролцуулан хийж хэвшээд байна.

2014 оны жилийн эцсийн мэдээний танилцуулгыг боловсронгуй болгон гаргаж 80 ширхэг хэвлэн тараасны зэрэгцээ сар бүрийн танилцуулгыг сүлжээгээр өгөх, фэйсфүүк Вэб хуудсанд тавих зэргээр сурталчлах ажлыг хийж байна. Мөн “Дундговийн амьдрал” сонинд улирлын мэдээний бичмэл танилцуулгыг тогтмол хэвлүүллээ.

ҮСХ-ноос жил бүр гаргадаг Монгол улсын статистикийн эмхэтгэлийг ҮСХ-ноос 26 ширхэгийг хүлээж аваад сумдад болон Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх хэлтэс, агентлагуудад тархааж эхлээд байна.

Жил бүр заавал хийх ХАА-н салбарын танилцуулга, Хүн ам, өрхийн үндсэн үзүүлэлтүүдийн танилцуулга, аж үйлдвэр, барилгын салбарын танилцуулга, ажил эрхлэлтийн танилцуулгыг хугацаанд нь хийж иргэдийн хурлын тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга түүний орлогч, Засаг даргын тамгын газрын дарга, тамгын газрын харьяа хэлтэс, агентлагын дарга нарт хэвлэн тарааж танилцуулж, мөн сар бүрийн хэвлэлийн бага хуралтай хамт салбар бүрийн танилцуулгаар аймгийн хэвлэл мэдээллийн ажилтнууд болон аймгийн ЗДТГ-н хэлтсүүдийн бие төлөөлөгч нарт мэдээлэл хийж хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж байна.

- Хөдөө аж ахуйн салбарын 2014 оны танилцуулгыг 2015 оны 3 сарын 30-ны өдөр хэвлэж 15 ширхэгийг аймгийн удирдлага, хэлтэс агентлагийн дарга нарт, АИТХурлын нийт 35 төлөөлөгч, 15 сумын засаг дарга, ХАА хариуцсан мэргэжилтэнүүдэд цахимаар хүргүүллээ. Мөн аймгийн вэб хуудас, фэйсбүүк зэргээр олон нийтэд тархааж байна.



2015 оны 4 сарын 3-ны өдөр аймгийн ХХААЖДҮГазрын дарга, мэргэжилтнүүд, АЗДТГазрын холбогдох мэргэжилтэнүүдээс бүрдсэн нийт 16 хэрэглэгчдэд хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Уянга ХАА-н салбарын танилцуулгаа танилцуулж харилцан санал, дүгнэлт солилцоо.



- 2014 оны хүн амын ажил эрхлэлт, ажилгүйдлын танилцуулгыг ажиллах хүчний түүвэр судалгааны үр дүнгээр хугацаанд нь бэлтгэн 16 хувь хэвлэн Аймгийн удирдлагууд болон холбогдох хэлтэс агентлагуудад тархаалаа. Мөн аймгийн вэб хуудсанд байршууллаа. Хүн амын ажил эрхлэлт, ажилгүйдлын танилцуулгыг 6 дугаар сарын статистик мэдээний танилцуулгын хэвлэлийн бага хуралтай хавсарган сэтгүүлчид холбогдох байгууллагын хүмүүст танилцууллаа.
- 2014 оны жилийн эцсийн хүн ам, өрхийн нийгмийн гол үзүүлэлтүүдээр танилцуулгыг бэлтгэн 2015 оны 4 сарын 30-ны өдөр хэвлэн гаргалаа. Мөн аймгийн нийгэм, эдийн засгийн 4 сарын танилцуулгатай хамт хэвлэлийн бага хурлыг 5 сарын 12 ны зохион байгуулж, хүн ам, өрх, өрхийн нийгмийн гол үзүүлэлтүүдээр хийсэн танилцуулгыг 12 хэвлэл мэдээллийн ажилтнууд, албан газар байгууллагын удирдлага, мэргэжилтнүүдэд танилцуулж санал бодлыг нь сонсож, олон түмэнд хүргэлээ.



Энэхүү хэвлэлийн бага хуралд Дундговь ТВ сэтгүүлч, аймгийн олон нийттэй харьцах албаны мэргэжилтэн АЗДТГ-ын хэлтсийн төлөөллүүд, болон аймгийн хөдөлмөрийн хэлтэс, ЭМГ, БСГ, Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс, ХАААлба, УБХэлтэс, ТГ, БТСпортын газар зэрэг албаны хүмүүс оролцлоо.

- Дундговь аймгийн Статистикийн хэлтсээс аймгийн 2014 оны жилийн эцсийн аж үйлдвэр, барилгын салбарын танилцуулгыг бэлтгэн 2015 оны 06 сарын 09-ны

өдөр хэвлэн гаргалаа. Мөн Аж үйлдвэр, барилгын салбарын танилцуулгаар 2015 оны 06 сарын 11 ны өдөр аймгийн хэвлэл мэдээллийн ажилтнууд болон аймгийн ЗДТГ-н хэлтсүүдийн бие төлөөлөгч нарт мэдээлэл хийн тархаалаа.



Аж үйлдвэр, барилгын салбарын гол үзүүлэлтүүдээр танилцуулгыг бэлтгэж, нийт хэвлэмэл байдлаар 20 ширхэгийг хэвлэж, аймгийн удирдлага, хэлтэс агентлагийн дарга нарт, 15 сумын засаг дарга, төрийн сангийн мэргэжилтнүүдэд цахимаар хүргүүлээ.



2014 оны аж үйлдвэр, барилгын салбарын танилцуулгын тархаалт

Овог нэр	Албан тушаал	Хүлээн авсан хувийг дарга үзэж
1. С.Од-Ордина	Аймгийн Засаг дарга	
2. С. Бударжав	ИТХ-ын дарга	
3. Н.Мандурайхан	Засаг даргын орлогч	
4. П.Бямбалхагва	Аймгийн тэмцэн газрын дарга	
5. А.Ганбат	СТХХалтсийн дарга	
6. Б.Тувшинбаяр	ХХХалтсийн дарга	
7. Ж.Нармандах	Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга	
8. С. Ягванчимэг	ТЭУХалтсийн дарга	
9. Д.Дулмаа	НХХалтсийн дарга	
10. С.Хулан	ОНХА-ны дарга	
11. Н.Тувшинмаргал	Статистикийн хэлтсийн дарга	
12. С.Намжилмаа	Хөдөлмөрийн хэлтэс	
13. Ганбаатар	Халамж үйлчилгээний хэлтэс	
14. Ц.Буянгарал	БСГ-ын дарга	
15. Ч.Баяраа	НДХХалтсийн дарга	

6/9/2015
ДУНГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Танилцуулгын тайлангуудыг хугацаанд нь явуулсан тайланд тархаасан жагсаалтын хувийг фото зургийн хамт хавсаргаж хэвшсэн билээ.

IV БҮЛЭГ. ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТ,
ТӨСӨВТ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, АШИГЛАЛТ

14. ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТ (Ш14)

Хэлтсийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Үндэсний статистикийн хорооны даргаар батлуулан ажилласан ба нийтдээ хэрэгжүүлэх 34 ажил төлөвлөгдсөн ба аймгийн Засаг даргын орлогчоор улирал бүрд хийх хэлтсийн ажлын төлөвлөгөөг батлуулан биелэлтий нь тооцон ажиллаж байна. Оны эхэнд хэлтсийн даргатай хөдөлмөрийн гэрээ байгуулж, жил, сарын ажлын төлөвлөгөөг хэлтсийн даргаар батлуулан мөрдөн ажиллаж байна.

"Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам"-ын хэвсрэлт 2

2015 ОНЫ ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

НЭГ. ТАЛУУДЫН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

1. Төрийн жинхэнэ албан хаагчийн үүргийн биелэлт

1.1. Гэрээнд тусгагдсан, тусгай ажил, үйлчилгээнээс бусад **13 нийт ажил, үйлчилгээ (гарц)-ний** хэрэгжилтийг ажил, үйлчилгээ тус бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа) бүрээр тооцсоны үндсэн дээр дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 1

№	Гэрээнд тусгагдсан нийт ажил, үйлчилгээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа) (орц)	Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацааны шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин) (гарц)	Тухайн нийт ажил, үйлчилгээний биелэлтэд менежерийн өгсөн үнэлгээ (Нийт ажил үйлчилгээ бүрийн биелэлтэд 0-30 он)
Нэг. Статистикийн тогтолцоог бэхжүүлэх зорилтын хүрээнд			
1	Статистикийн хэлтэст сумдаас ирүүлэх албан ёсны статистикийн мэдээ тайлангийн график батлан өгч мөрдүүлнэ.	Мэдээ тайлангийн графикийг 2015 оны эхэнд шинэчлэн графикт хувиар гарган сумдын төрийн сангийн мэргэжилтэнүүдэд хүргүүлэн мөрдөн ажиллаж байна.	30
2	Хэлтсийн ажлын төлөвлөгөө боловсруулах, тайлан бичих, үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэнэ, зөвлөгөөн хийнэ.	Жилийн эхэнд хэлтсийн даргатай үр дүнгийн гэрээ байгуулан гэрээг хагас бүтэн жилээр биелэлт гарган ажиллаж байна. Өөрийн хариуцсан салбарын үйл ажиллагааг сараар төлөвлөн хэрэгжилтийг сар	30

Энэ оны эхний хагас жилийн ажлын төлөвлөгөөнд нийт 34 ажил төлөвлөснөөс тасарсан ажил байхгүй байна. Төлөвлөгөөний биелэлтийн гүйцэтгэл, хийсэн ажлын тайланг улирал бүр бичиж даргад танилцуулж, дараа улиралын төлөвлөгөөгөө хийж батлуулан ажиллаж хэвшлээ. АймгийнЗДТГ-т 7 хоногтүтамдгүйцэтгэсэнажлынтайлангболондараа 7 хоногийнажлынтөлөвлөгөөгөгч хэвшээд байна. Мөн долоо хоног бүрийн хэлтсийн цуглаанд сууж, хийсэнажлаа дүгнэж, дараа 7 хоногт хийх ажлаа төлөвлөж, ярилцаж байна. Төрийн албан хаагчдын хувийн хэргийн баяжилтыг жил бүрийн эцэст хийж заншсаны дагуу өөрийн хувийн хэргийн материалыг /2015/ оноор бүрдүүлж төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний бүртгэлийг хуваарийн дагуу хийж өгөв.

БАТЛАВ. ХЭЛТСИЙН
СТАТИСТИКИЙН ДАРГА *Н.ТУВШИЖАРГАЛ*

Барилга, ТББ, Газар тариалан, сүм хийд хариуцсан мэргэжилтэн
Баяраа овогтой Энхтуяагийн 2015 оны 2-р улиралын ажлын төлөвлөгөө

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт / тоо, чанар /	Дуусах хугацаа
Нэг. Статистикийн тогтолцоог бэхжүүлэх зорилтын хүрээнд			
1	Аймгийн нийгэм, эдийн засгийн байдлын сар, улиралын статистикийн мэдээг нэгтгэж, танилцуулгыг бэлтгэж гаргах	1. 2015 оны 5,6 сарын танилцуулгад хариуцсан салбарын үзүүлэлтүүдийг оруулна. 2. Танилцуулгыг ИТХ, ЗД, Тамгын газрын дэргэдэх хэлтэс албад болон бусад хэрэглэгчид, сумдад тархаана.	Сар бүрийн 10 ны дотор
2	Вэб баяжилтанд мэдээлэл оруулах.	1. Сарын бюллетень, танилцуулгад хариуцсан салбарын мэдээллийг оруулан web-д байршуулна.	Сар бүрийн 15 ны дотор жилдээ
3	Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, ажилтны мэргэшил, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх	1. ҮСХ-ны сургалтын хөтөлбөрийн дагуу ажилтнуудын цахим сургалтад хамрагдана.	Тухай бүр
Хоёр. Албан ёсны статистикийн мэдээллийн гаргалт, хамралт, бодит байдлыг сайжруулах, орон нутгийн бодлого төлөвлөлтөд шаардагдах мэдээллийг бүрдүүлж хэрэглээг өргөтгөх зорилтын хүрээнд			
1	ҮСХ-ны даргын 2015 оны А/Б тоот тушаалаар баталсан мэдээ тайлагнийн графикийн дагуу улсын хэмжээний судалгаа болон албан ёсны статистикийн мэдээ, мэдээллийг маягтаар цуглуулах	1. Тарилсан талбайн мэдээ (ХАА-6) 2. Нийтийн орон сууцны үнийн мэдээ (ОСҮ-1)	5,6 сарын 4 2 удаа 6 сарын 21 1 удаа
2	Цаг үеийн шаардлагаар ҮСХ-ноос эдийн засгийн статистикийн чиглэлээр нэмэлтээр мэдээллийг хугацаанд нь цуглуулна.	DevInfo мэдээллийн сан, МХХ-ын мэдээллийн сангийн танилцуулгад хариуцсан салбараар хийж Мэдээний мэдлт, заавар, аргачлалыг сүм, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлж, мэдээ цуглуулах ажлыг графикт хугацаанд зохион байгуулна.	Сар бүр Тухай бүр

Хэлтсийн хүний нөөцийг бэхжүүлэх зорилгоор төрийн албаны салбар зөвлөлийн нөөцөд бүртгэлтэй байсан Б.Энхтуяаг ҮСХороо, Төрийн албаны салбар зөвлөлд холбогдох баримтыг хүргүүлэн зөвшөөрлыг авч барилга, ТББ, газар тариалн, сүм хийд хариуцсан мэргэжилтнээр томилоод байна. Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллого явагдаж байгаатай холбогдуулан аймгийн төвийн 2000-аас дээш хүн амтай 4 багт 6 сарын хугацаатай 4 гэрээт ажилтан авч ажиллуулж байна.

Хүнийн нөөцийн мэдээллийн сангийн баяжилтыг хэлтсийн мэргэжилтэн Т.Бямбасүрэнгийн ажил үүргийн хувиарт

Барилга, ТББ, Газар тариалан, сүм хийд хариуцсан мэргэжилтэн
Баяраа овогтой Энхтуяагийн 2015 оны 2-р улиралын ажлын төлөвлөгөөний биелэлт

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт / тоо, чанар /	Дуусах хугацаа	Биелэлт
Нэг. Статистикийн тогтолцоог бэхжүүлэх зорилтын хүрээнд				
1	Аймгийн нийгэм, эдийн засгийн байдлын сар, улиралын статистикийн мэдээг нэгтгэж, танилцуулгыг бэлтгэж гаргах	1. 2015 оны 5,6 сарын танилцуулгад хариуцсан салбарын үзүүлэлтүүдийг оруулна. 2. Танилцуулгыг ИТХ, ЗД, Тамгын газрын дэргэдэх хэлтэс албад болон бусад хэрэглэгчид, сумдад тархаана.	Сар бүрийн 10 ны дотор	4, 5 сарын танилцуулгад хариуцсан салбарын мэдээллийг оруулсан
2	Вэб баяжилтанд мэдээлэл оруулах.	1. Сарын бюллетень, танилцуулгад хариуцсан салбарын мэдээллийг оруулан web-д байршуулна.	Сар бүрийн 15 ны дотор, жилдээ	Мэдээлээ өгсөн
3	Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, ажилтны мэргэшил, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх	1. ҮСХ-ны сургалтын хөтөлбөрийн дагуу ажилтнуудын цахим сургалтад хамрагдана.	Тухай бүр	ҮСХ-ноос зохион байгуулсан цахим сургалтад 2 удаа хамрагдсан
Хоёр. Албан ёсны статистикийн мэдээллийн гаргалт, хамралт, бодит байдлыг сайжруулах, орон нутгийн бодлого төлөвлөлтөд шаардагдах мэдээллийг бүрдүүлж хэрэглээг өргөтгөх зорилтын хүрээнд				

оруулан баяжилтыг тогтмол хийж байна. Тухай бүр хэлтсийн мэргэжилтэн, төрийн сан, багийн засаг дарга нар солигдох бүрт мэдээллийг шинэчлэн нэмэлт мэдээллийг баяжуулж ажиллаж байна.




Хэлтсийн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллах, нийгмийн баталгааг хангах, мэдлэг мэргэжилээ дээшлүүлэхэд байнга анхаарч ажиллаж байна. Ажлын байрны дасгал хөтөлгөөнийг идэвхжүүлэх, мөн 7 хоног бүр аймгийн байгаль орчны газартай хамтран 2 цаг спорт зааланд тоглох зэрэг ажлыг тогмол хийж хэвшээд байна.

15. ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ӨГӨӨЖ (Ш15)

Мэдээтайландтавиххяналт, шалгалтынграфикчилсантөлөвлөгөөгбаталж, оныэхнээсмөрдүүлэнажиллажнэгж, байгууллагадахьСтатистикийнтухайМонгол Улсын хуулийнхэрэгжилт, Статистикийнмэдээллийнүндэслэл, үнэнзөв, шуурхайбайдал,статистикхамрагдалтынбайдлыгшалгав.

Графикийн дагуу бүх сумдадхэлтсийн мэргэжилтнүүд ажиллаж, ажлыг нь удирдамжийн дагуу шалган тусалж ажлын чиглэл, зааварчлага өгч, илэрсэн дутагдал зөрчлийг засуулах арга хэмжээ авч ажиллалаа.Мөн хэлтсийн мэргэжилтнүүдэд өөрсдийн хариуцсан салбарын аж ахуй нэгжийг тогтмол шалгаж заавар зөвлөгөө өгсөн.

Хүн ам, орон сууцны завсрын тооллого, жилийн эцсийн мал тооллогоор 15 суманд 5 баг гарч хяналтын тооллогыг амжилттай зохион явууллаа. Уг хяналтаар өндөршил, гурвансайхан сумдад зөрчил илрүүлж засаг даргын зөвлөлийн хурлаар оруулж шийдэхээр төлөвлөж байна.



БАТЛАВ
ДУНДГОВЬ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Н.ТҮВШИНЖАРГАЛ

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН 2015 ОНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ
ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2014.03.10

№	Ажиллах сум, байгууллага, ААН	Хугацаа	Хариуцан гүйцэтгэгч	Хүрэх үр дүн
1	Дэлгэрцогт, Адаацаг, Сайнцагаан	1-р улирал, 3-р улирал	Н.Түвшинжаргал Т.Бямбасүрэн	Анхан шатны статистик мэдээлэл үнэн бодитой, түргэн шуурхай болно.
2	Говь-угтаал, Дэрэн, Цагаандэлгэр	2-р улирал, 4-р улирал	Н.Түвшинжаргал Г.Баясгалан	Анхан шатны статистик мэдээлэл үнэн бодитой, түргэн шуурхай болно.
3	Гурвансайхан, Баянжаргалан, Өндөршил	2-р улирал, 4-р улирал	Н.Түвшинжаргал С.Доржжанд	Анхан шатны статистик мэдээлэл үнэн бодитой, түргэн шуурхай болно.
4	Өдзийт, Хулд, Луус, Зан	1-р улирал, 3-р улирал	Н.Түвшинжаргал Ж.Уянга	Анхан шатны статистик мэдээлэл үнэн бодитой, түргэн шуурхай болно.
5	Дэлгэрхангай, Сайхан- овоо, Эрдэнэдалай	2-р улирал, 3-р улирал	Н.Түвшинжаргал Б.Зүмбэрэл	Анхан шатны статистик мэдээлэл үнэн бодитой, түргэн шуурхай болно.
6	Хариуцсан салбарын аж ахуйн нэгжүүдэд шалгалт хийх /2-с доошгүй/	Сар бүр	Н.Түвшинжаргал, хэлтсийн ажилтнууд	Анхан шатны статистик мэдээлэл үнэн бодитой, түргэн шуурхай болно.

ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН: АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ж.УЯНГА

Албан ёсны статистик мэдээ, мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавих зорилгоор хэлтсийн дарга болон мэргэжилтнүүджилийн эцсийн байдлаар Луус, Хулд, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Гурвансайхан, Баянжаргалан, Адаацаг, Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Дэрэн, Дэлгэрцогт, Эрдэнэдалай зэрэг 15 суманд төрсийн сан, багийн засаг дарга нарын сарын мэдээний анхан шатны хөтөлгөө болон түүний үнэн бодит байдал, хагас жилийн малын түүвэр судалгааны явц, зохион байгуулалтанд хяналт хийхийн зэрэгцээ бусад багийн дарга нарын туршлагыг хуваалцан зөвлөгөө өглөө.



Статистикийн хэлтсийн 2015 онд хяналт, шалгалт хийх хэлтсийн даргаар батлуулсан ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Удирдамжийн дагуу Хүн ам, орон сууцны завсрын тооллогын хяналтын ажлаар Хулд, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумдад хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Уянгаар ахлуулан мэргэжилтэн С.Доржханд, Т.Бямбасүрэн, Гурвансайхан, Баянжаргалан, Говь-Угтаал, Дэрэн, Цагаандэлгэр сумдад хэлтсийн дарга Н.Түвшинжаргалаар ахлуулан гэрээт ажилтан Г.Баясгалан, ХАОСТооллогын гэрээт ажилтан Н.Урансайхан нарын бүрэлдэхүүнтэй баг 11 сарын 17-оос 5 хоногийн хугацаатай ажиллаа. Мөн Адаацаг, Дэлгэрцогт суманд мэргэжилтэн Т.Бямбасүрэн, Б.Энхтуяа нар 11 сарын 23-аас 3 хоногийн хугацаатай ажиллаа.



Хяналтаар ажиллах явцад сумдын Хүн ам, орон сууцны завсрын тооллогын комиссын ажлын явц, түүнд тулгарч буй бэрхшээл, цаашид хийх ажлын төлөвлөгөө болон багийн Засаг дарга нарын хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэрийг онлайн програмтай тулгаж програмын алдааг өрх бүрээр орж шалган засууллаа. Сумдын хувьд хүн ам орон сууцны завсрын тооллогын комисс байгуулж, ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Албан ёсоор шилжээгүй оюутнуудыг хотын хороодууд бүртгэж, шилжүүлэн авч байна. Зарим хороонууд шилжин ирсэн хүмүүсийг энд

бүртгэсээр байхад шилжүүлгий нь хийж өгөхгүй байна. Мөн шилжээгүй иргэдийг давхар бүртгэж байна. Бага насны хүүхдийг хүртэл өрхөөс нь таслан бүртгэж улайлгаж байна. Мөн шинээр төрсөн хүүхдүүдийг бүртгэж болохгүй байна гэсэн бэрхшээл ярьж байлаа.

16. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА (Ш16)

Нягтлан бодох бүртгэлийн стандартыг нэвтрүүлэн, анхан шатны бүртгэлүүдийг заавар журмын дагуу хөтөлж, батлагдсан төсвийг зардлын зүйл ангид багтаан үр ашигтай захиран зарцуулж байна. Аймгийн аудитын байгууллагаар 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд баталгаажуулалт хийлгүүлж зөрчилгүй гэсэн дүгнэлт гарсан ба цаашид мөрдөж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төсвөөс олгож буй аливаа урамшуулал, унаа хоолны хөнгөлөлтөөс хүн амын орлогын албан татварын 10 хувийг суутган тооцож, татварын хэлтсийн зохих дансанд төвлөрүүлэн ажиллав.



Нягтлан бодох бүртгэлийн стандарт АСОЛОУС-програмд бүх санхүүгийн гүйлгээ, үндсэн хөрөнгө, цалингийн тооцоонуудыг оруулж хэвшсэн ба батлагдсан төсвийг зөв зохистой, зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, өр авлага үүсгэхгүйгээр, арвилан хэмнэлтийн бодлогыг тууштай нэвтрүүлэн ажиллаж байна. Мөн шилэн дансны мэдээллийн хэлтсийн вэб хуудсанд холбож хэлтсийн төлөвлөгөө, сар бүрийн мэдээ, шаардлагтай мэдээллийг тогтмол оруулж байна.

Хэлтсийн ажилтнуудад картаар эзэмшүүлж байгаа үндсэн болон эргэлтийн хөрөнгийн ашиглалт хамгаалалтанд нь байнгын хяналт тавьж ажиллаж байна.

Жилийн эцсийн санхүүгийн тайлан балансыг 1-р сарын 10-ны дотор гаргахаар бэлтгэл ажлыг хийж байна.

ДУНДГОВЬ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2015.12.30